

## ЕБС-ИЙН СУРАЛЦАГЧДАД АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

(9-р анги удирдсан багш нарт зориулсан сургалтын модуль)

Г. Нарангэрэл /Нийслэлийн лаборатори 20 дугаар сургуулийн сургалтын менежер

gnarangerel2005@gmail.com

### Модулийн зорилго:

БШУ-ны сайдын 2021 оны А/199 тоот тушаалаар батлагдсан “ЕБС-ийн хичээлээс гадуурх үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөр” –ийн “Эх оронч болон хөдөлмөрийн хүмүүжлийг дэмжих” 7 дугаар зорилтын хүрээнд “суралцагчдад суралцах чиглэл, мэргэжлээ тодорхойлж, ухамсартай сонгоход дэмжлэг үзүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэх”-ээр заасныг үндэслэн 9 дүгээр анги удирдсан багш нарт хичээлээс гадуурх ажлын хүрээнд суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг зохион байгуулахад нь арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор энэхүү модулийг боловсруулав.

### Модуль хэрэгжүүлэх зөвлөмж:

Суралцагчид дор хаяж дараах 5 гол шилжилттэй нүүр тулдаг. Үүнд:

- Хүүхэд наснаас өсвөр нас түүнээс насанд хүрэхтэй холбоотой гарах шилжилт;
- Бага ангиас дунд анги, түүнээс ахлах ангид орох шилжилт;
- Сургууль төгсөөд их дээд сургууль эсвэл мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцах, түүнээсээ ажил хөдөлмөр эрхлэх шилжилт;
- Хөдөлмөрийн зах зээл дотор гардаг өөрчлөлт;
- Нийгэмд тогтмол явагддаг өөрчлөлт, тухайлбал глобалчлал болон техник технологийн нөлөөгөөр гарч байгаа өөрчлөлт шилжилтүүдийг энд дурьдаж болно.

Энэ эмх замбараагүй өөрчлөлттэй зэрэгцүүлээд суралцагчид өөрийгөө таньж мэдэх, ойлгох, ажил хөдөлмөрийн ертөнцийн талаар мэдэх, богино, урт хугацааны ухаалаг сонголт хийх зэрэг хэрэгцээ шаардлагуудтай нүүр тулж байна.<sup>1</sup> Иймд ерөнхий боловсролын сургуулийн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны гол үүрэг нь *суралцагчдад дээр дурдсан шилжилтүүдээ удирдах, суралцах чиглэл, ажил мэргэжилтэй холбоотой ухаалаг шийдвэр гаргахад хэрэгтэй мэдээлэл цуглуулах, түүнийг боловсруулах, оновчтойгоор үйл хэрэг болгон хэрэгжүүлэхэд нь* дэмжих туслахад оршино. 9 дүгээр ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг амжилттай хэрэгжүүлэхийн тулд анги удирдсан багш танд дараах зүйлүүдийг анхаарч ажиллахыг зөвлөж байна:

- ✓ АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд 2016, 2018 онуудад боловсруулан гаргасан гарын авлагуудаас ажил мэргэжлийн хөгжлийн онол, үзэл баримтлал, үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулгын хүрээ, анги бүрд суралцагчдад эзэмшүүлэх чадвар, хэрэгжүүлэх арга зүйн талаар уншиж судлан, үр дүнтэй хэрэглэх;
- ✓ 9 дүгээр ангийн суралцагчид 9 дүгээр ангиа төгсөөд цаашид хаана, ямар чиглэлээр суралцах вэ, 10 дугаар ангид элсэн суралцах уу, МСҮТ –д элсэн орж мэргэжлийн боловсрол эзэмших үү; ажил мэргэжил болон сургалтын ямар боломжууд байна вэ, хаанаас мэдээлэл олж авах вэ, ажил мэргэжлийн сонголтдоо яаж хийх вэ зэрэг асуудлуудтай тулгардаг. Эдгээр асуудлуудаа ухаалгаар шийдэж, дунд ангиас ахлах анги, мэргэжлийн сургалт, боловсролын байгууллага руу шилжих шилжилтээ ухамсартайгаар удирдахад нь даасан ангийн суралцагчиддаа дэмжлэг үзүүлж, зөв чиглүүлж өгөх нь 9 дүгээр анги удирдсан багш таны маш чухал ажил үүргийн нэг юм. Иймээс суралцагчдын нас сэтгэхүй, хувь хүний хөгжлийн онцлогийг харгалзан ажил мэргэжлийн чиг баримжаа

<sup>1</sup> БСШУЯ, АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” –“Багшийн гарын авлага”, УБ, 2016

олгох сургалт, үйл ажиллагааны агуулга, зохион байгуулах арга хэлбэрийг оновчтой төлөвлөж, үр дүнтэй хэрэгжүүлэх;

✓ Суралцагчдад суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж, ухаалаг шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлж, зөвлөн туслахдаа суралцагч бүр нийгмийн, сэтгэл хөдлөлийн болон биеийн хөгжлийн хурдаараа, ажлын ертөнц болон сургалтын талаарх үзэл бодлын төлөвшлөөрөө, өөрийн сонирхол, ур чадварын талаар ойлгох, ирээдүйгээ төсөөлөх, төлөвлөх чадамжаараа ялгаатай байдгийг тооцож ажиллах;

✓ Суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны тулгуур асуудлын нэг нь ажил мэргэжил, сургалтын талаарх чанартай, бодитой, шинэлэг мэдээлэл байдаг. Ялангуяа, ЕБС-ийн 8, 9 дүгээр ангийн суралцагчдад чиглэсэн мэдээлэл нэлээд бага байдаг. Ажил мэргэжил, суралцах чиглэлийн талаар суралцагчдын дунд олон янзын төөрөгдөл гарахаас сэргийлж, анги удирдсан багш шинэлэг, үнэн бодит мэдээлэл цуглуулах, эх сурвалж, материалыг бэлтгэх, цахим хэлбэрт шилжүүлэх, түүнийгээ үр дүнтэйгээр ашиглах;

✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг дэмжих олон янзын нөөц, бололцоо байдаг: эцэг эх, ажил олгогч, ТББ, төгсөгч, МБС, ДБСБ, төвүүд, Хөдөлмөрийн хэлтэс, вэбсайт, ажил мэргэжилтэй холбоотой ном, гарын авлага гэх мэт.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлэхийн тулд эдгээр нөөцийг оновчтой ашиглах;


✓ Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаагаар суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадвар нь тэднийг амьдралын сонголт, чиглэлээ удирдан залахад хэрэглэгдэх насан туршийн мэдлэг, чадвар байх тул энэхүү үйл ажиллагааг тасралтгүй явагдах үйл явц гэж үзэн тогтвортой хэрэгжүүлэх.

### **Агуулга хэрэгжүүлэх сургалтын цагчилсан төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга зүй**

Дунд ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийг “ойлголт”, “үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх” гэсэн 2 агуулгын хүрээнд хэрэгжүүлэх /Зураг 1/ бөгөөд “Ойлголт” агуулга нь *өөрийгөө ойлгох, ажлын ертөнцийн талаар ойлгох* болон суралцах чиглэл, ажил мэргэжилтэй холбоотой сонголт хийх, шийдвэр гаргахад *нөлөөлөх хүчин зүйлийн талаар ойлгох* гэсэн 3 үйл ажиллагааг багтаана.

“Үйл хэрэг болгох, хэрэгжүүлэх” агуулга нь *зорилгоо дэвшүүлэх, шийдвэр гаргах үйл хэрэг болгох болон эдгээрийг эргэн харж дүгнэх* гэсэн үйл ажиллагаануудаас бүрдэнэ.

Зураг 1 . Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулга



9 дүгээр ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахдаа үйл ажиллагаагаа **өөрийн сонирхол, ур чадвар, арга барил, давуу талаа хөгжүүлэх, ажил мэргэжлийн талаар мэдээлэл илүү нарийвчлан судлах, нөлөөллийг ойлгож удирдах, ахлах ангийн хичээлээ ажил мэргэжлийн төлөвлөгөөтэй уялдуулан сонгох** чадварыг эзэмшүүлэхэд чиглүүлнэ. Энэхүү модулиар танилцуулж байгаа төлөвлөгөөний загварыг та бүхэн өөрийн сургуулийн зорилгод нийцүүлэн сайжруулан ашиглах боломжтой.

9 дүгээр ангид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг хичээлээс гадуурх ажлын хүрээнд дараах арга хэлбэрүүдээс сонгон хэрэгжүүлж болно:

- 1. Анги танхимд суурилсан эсвэлд цахим сургалт:** АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд гаргасан Багшийн гарын авлага, бусад эх сурвалжуудыг ашиглан суралцагчдад суралцах чиглэл, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хичээл заах, мэдээлэл өгөх, дасгал даалгавар ажиллуулах зэргээр хичээлийн жилийн туршид хэрэгжүүлэх боломжтой.
- 2. Мэдээлэл цуглуулж, бусадтай хуваалцах:** Суралцагчид бие даан ажил мэргэжил, мэргэжлийн боловсрол олгох сургалтын байгууллагын талаар ном, гарын авлага, вэбсайтаас мэдээлэл цуглуулж, боловсруулан бусадтайгаа мэдээллээ хуваалцах
- 3. Туршлага судлах :** Ажил хөдөлмөртэй холбоотой туршлага судлах үйл ажиллагаанд оролцох явдал нь суралцагчид ажил мэргэжлийн талаар хангалттай ойлголт мэдлэгтэй болох, энэ чиглэлээр хөгжихөд чухал хувь нэмэр оруулдаг. Зочин урьж ярилцлага уулзалт хийх, ажлын байранд зочилж, ажиглалт хийлгэх, ажил мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулах, мэргэжлийн болон их дээд сургуульд зочилж, хөтөлбөртэй танилцах, сайн дурын ажилд оролцох зэрэг үйл ажиллагаануудыг энд дурдаж болно.
- 4. “Сонголтын 7 хоног” үйл ажиллагаа:** 9 дүгээр ангиа төгсөхийн өмнө 7 хоногийн турш багш, эцэг эх, суралцагчид хамтран 10 дугаар ангийн хичээл сонголтыг хийж түүний дагуу суралцах чиглэл, ажил мэргэжлийн төлөвлөгөө боловсруулна. Энэхүү үйл ажиллагааг хэрэгжүүлэх зөвлөмжийг та бүхэн 2016 онд “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-өөс 2016 онд гаргасан “Багшийн гарын авлага” –аас дэлгэрүүлэн унших боломжтой.
- 5. Ганцаарчилсан дэмжлэг:** Суралцагч бүрт сонголт хийхэд нь зөвлөгөө өгөх

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагаа нь суралцагчдыг өөрийн сурах үйл ажиллагаа, хүсэл тэмүүлэл, зорилгоо дээд зэргээр ашиглах боломжийг олгоход чиглэсэн байх ёстой тул багш олон янзын арга хэлбэр сонгон, сургалтын идэвхтэй аргуудыг бүтээлчээр, үр дүнтэй ашиглан хэрэгжүүлэх нь зүйтэй.

Анги танхимын сургалтад ашиглах арга зүй:	Туршлага судлахад ашиглах арга зүй:
<ul style="list-style-type: none"> <li>• Оюуны зураглал</li> <li>• Тархины шуурга</li> <li>• Венийн диаграмм</li> <li>• Мэдээлэл, танилцуулга хийх</li> <li>• Хэлэлцүүлэг хийх</li> <li>• Бичвэртэй ажиллах</li> <li>• Хэсэгчилсэн эрэл хайгуул хийх</li> <li>• Асуудал дэвшүүлэн тайлбар хийх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Ярилцлага авах</li> <li>• Ажлын байранд ажиглалт хийн тэмдэглэл хөтлөх</li> <li>• Асуулга авах</li> <li>• Жишээн дээр суралцах</li> <li>• Аялал</li> </ul>

**9 дүгээр ангийн суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох  
үйл ажиллагааны төлөвлөгөө /загвар/**

**Зорилго:** Суралцагчдад ажил мэргэжлийн зорилгоо тодорхойлж, дунд ангиа төгсөөд цаашид үргэлжлүүлэн суралцах чиглэлээ сонгох, суралцах чиглэл, ажил мэргэжлийн төлөвлөгөөгөө үйл хэрэг болгоход нь дэмжлэг үзүүлэх, зөвлөн туслах

**Хугацаа:** 2021-2022 оны хичээлийн жил

Арга хэлбэр	Д/д	Үйл ажиллагаа	Хэрэгжүүлэх хугацаа	Ашиглах материал
<b>1-Р УЛИРАЛ</b>				
Сургалт <i>Танхимаар эсвэл цахимаар</i>	1	Дасгал 1. Өөрийгөө таних : Профайл	4 цаг	www.myfuture.mn сайт Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 93
	2	Дасгал 2. Ажлын ертөнцийг таньж мэдэх Бүтээгдэхүүн	1 цаг	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 93 <a href="http://www.myfuture.mn">www.myfuture.mn</a> <a href="http://www.mergejil.mn">www.mergejil.mn</a>
	3	Дасгал 3. Нөлөөлөл Хэвлэл мэдээлэл	1 цаг	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 94 <a href="http://www.myfuture.mn">www.myfuture.mn</a>
Туршлага судлах	4	МСҮТ, коллежид зочлох		Багш эцэг эх, сургуулийн удирдлагатай хамтарч зочлох МСҮТ, коллежийг сонгоно
Мэдээлэл цуглуулах	5	Ангийн буланд ажил мэргэжлийн талаар илүү сонирхолтой мэдээлэл мэдээллээ байршуулж хуваалцах	Баг бүр долоо хоногт 1 удаа	Ажил мэргэжилтэй холбоотой ном гарын авлага Ажил мэргэжилтэй холбоотой вэбсайт <a href="http://www.mergejil.mn">www.mergejil.mn</a> <a href="http://hudulmur-halamj.gov.mn">http //hudulmur-halamj.gov.mn</a>
<b>2-Р УЛИРАЛ</b>				
Сургалт <i>Танхимаар эсвэл цахимаар</i>	1	Дасгал 4. Урт/богино хугацааны зорилгууд	2 цаг	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 94
	2	Дасгал 5. Шийдвэр Хүч	1 цаг	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 95
	3	Дасгал 6. Үйл хэрэг Анкет	1	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 95
Туршлага судлах	4	Зочин урьж ярилцлага хийх	1 цаг	Суралцагчдын хамгийн их сонирхож, илүү олон зүйлийг мэдэхийг хүсч байгаа ажил мэргэжилтэй зочин урина.
Мэдээлэл цуглуулах	5	Ангийн мэргэжлийн сургалтын байгууллагуудын талаар олж мэдсэн мэдээллээ байршуулж хуваалцах	Баг бүр долоо хоногт 1 удаа	МСҮТ, коллеж, их дээд сургуулиудын вэбсайт
<b>3-Р УЛИРАЛ</b>				
Туршлага судлах	1	Ажил мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулах:	2 цаг	Сургуулийн нийгмийн ажилтан, МСҮТ, коллежийн сургалтын албатай хамтрана

	2	Ажлын байранд зочлох	7 хоногийн турш	Багш эцэг эх, сургуулийн удирдлагатай хамтарч зочлох үйлдвэр, аж ахуйн нэгжийг сонгоно. Суралцагчдыг сонирхолоор нь баг болгон өөр өөр ажлын байранд зочлуулж болно.
<b>Сургалт</b> <i>Танхимаар эсвэл цахимаар</i>	2	“Сонголтын 7 хоног” үйл ажиллагаа	1-2 долоо хоногийн турш	Багшийн гарын авлага. 2016 он Хуудас 74-84 Суралцагчийн гарын авлага /9 дүгээр ангийн суралцагчдад зориулсан/, 2016 он

### Модулиар 9 дугаар ангийн суралцагчдын эзэмших мэдлэг чадвар, үнэлгээ

Суралцагчид ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт, үйл ажиллагаанд хамрагдсанаар дараах мэдлэг, чадвартай болно.

*Хүснэгт 1. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн “Ойлголт” агуулгын хүрээнд 9 дүгээр ангийн суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар*

Үйл ажиллагаа	Дасгал даалгавар	Суралцагчийн эзэмших мэдлэг	Суралцагчийн эзэмших чадвар
Өөрийгөө таньж мэдэх, ойлгох	Дасгал 1. Өөрийгөө таних : Профайл	өөрсдийн сонирхол, чадвар, үнэт зүйлийн онцлог болон сонирхож байгаа таньж мэдэх, түүнийгээ хөгжүүлэх талаар мэдлэг ойлголттой болно.	Өөрийнхөө сонирхол, давуу талыг таньж мэдэх, чадвар, үнэт зүйлээ тодорхойлох чадвартай болно.
Ажлын ертөнцийг таньж мэдэх	Дасгал 2. Бүтээгдэхүүн	Монгол улсын хөдөлмөрийн зах зээл, ажлын ертөнцийн талаар ойлгож мэднэ. Түүнчлэн ажил мэргэжлийн боломжууд болон эдгээрээс өөртөө хамгийн сайн тохирсон ажил мэргэжлийн талаар мэддэг болно.	Ажил мэргэжлийн талаар судалгаа хийх чадвар хөгжинө.
	МСҮТ, коллежид зочлох		
	Ангийн буланд ажил мэргэжлийн талаар илүү сонирхолтой мэдээлэл мэдээллээ байршуулж хуваалцах		
Нөлөөллийг ойлгох	Хэвлэл мэдээлэл	ажил мэргэжлийн сонголт хийхэд хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон олон нийтийн мэдээлэл хэрхэн нөлөөлдөгийг ойлгоно.	Ажил, Мэргэжлийн сонголт хийж, шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлүүдийг удирдан зохицуулж сурна.

*Хүснэгт 2. . Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны хөтөлбөрийн “Үйл ажиллагаа болгон хэрэгжүүлэх” агуулгын хүрээнд 9 дүгээр ангийн суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар*

Үйл ажиллагаа	Дасгал даалгавар	Суралцагчийн эзэмших мэдлэг	Суралцагчийн эзэмших чадвар
Зорилгоо тодорхойлох	Дасгал 4. Урт/богино хугацааны зорилгууд	Суралцах чиглэл, ажил мэргэжлийн урт болон богино хугацааны зорилгоо тодорхойлох талаар мэдлэг, ойлголттой болно.	Суралцах чиглэл, ажил мэргэжлийн богино, дунд, урт хугацааны зорилгоо тодорхойлох чадвартай болно.
Сонголт хийх, шийдвэр гаргах	Дасгал 5. Хүч	Ажил мэргэжлийн чиг баримжаа, ахлах ангийн хичээлийн болон сургууль төгссөний дараах сургалтын оновчтой, зөв сонголт хийх талаар мэдлэг ойлголттой болно. Янз бүрийн ажил мэргэжлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэлтэй болно.	Ажил мэргэжлийн сонголтын дагуу суралцах чиглэл, ажил мэргэжлийн төлөвлөгөө хийх, энэ төлөвлөгөөний дагуу суралцах сургууль, ахлах ангид судлах хичээлийн сонголт хийх чадварт суралцана.
	Зочин урьж ярилцлага хийх		
	Ажил мэргэжил сурталчлах өдөрлөг зохион байгуулах:		
Ажлын байранд зочлох			
Үйл хэрэг болгох/ хэрэгжүүлэх	Дасгал 6. Анкет	<b>Өөрийгөө танилцуулах</b> сайн анкет бичихэд юу хэрэгтэй талаар ойлголттой болно	Өөрийгөө танилцуулсан анкет бичиж сурна.
Эргэж харж, дүгнэх	9-р анги	Сургалтын үр дүн болон явцаа эргэн харж дүгнэх	өнгөрсөн хичээлийн жилүүдэд яаж сурсанаа эргэцүүлэн сурлагын амжилтаа ахиулах зорилго дэвшүүлэх, төлөвлөгөө гаргах чадвар сайжирна.
Сонголтын 7 хоног үйл ажиллагаа		Өмнөх үйл ажиллагаагаар эзэмшсэн мэдлэгээ бататгана.	Бэлэн гарын авлага ашиглан дараах чиглэлээр өөрийгөө нээж илрүүлэх, мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлоход суралцана: <ul style="list-style-type: none"> <li>- Сонирхол,</li> <li>- Хөдөлмөрийн салбарууд,</li> <li>- Ажил мэргэжил,</li> <li>- Хичээл – дуртай хичээл, сайн хичээл, бэрхшээлтэй байдаг хичээл</li> <li>- Чадвар,</li> <li>- Үнэт зүйл,</li> <li>- Ажиллах арга барил,</li> <li>- Ур чадвар</li> <li>- Сонголт 1: Заавал сонгох</li> <li>- Сонголт 2: Сонгон гүнзгийрүүлэх</li> <li>- Баталгаажуулалт</li> </ul>

**Үнэлгээ:** 9 дүгээр ангийн суралцагчийн суралцах чиглэл ажил мэргэжлийн чиг баримжаагаа тодорхойлж, цаашид суралцах сургууль, ахлах ангийн хичээлээ сонгох чадварыг дараах арга хэлбэрээр үнэлж болно:

1. Ажил мэргэжлийн асуулга 1, 2

Сурагчийн гарын авлагад байгаа ажил мэргэжлийн асуулгаар дамжуулан суралцагчдаар ажил мэргэжлийн талаарх өөрийн үнэлгээ хийлгэж болно. Энэ асуулгад суралцагчдын ажил мэргэжлийн талаарх сэтгэлгээг үнэлэх асуултуудыг төлөвлөсөн бөгөөд асуулгын ялгаатай үр дүн энэ сэтгэлгээний богино хугацааны өөрчлөлтийг тодорхойлно. *Сэтгэлгээний өөрчлөлт нь тодорхой суралцагчийн төдийгүй тухайн ангийн нийт суралцагчдын ерөнхий хандлагыг илэрхийлнэ.*<sup>2</sup>

2. Үр дүнд сүүрилсэн үнэлгээ

Суралцагчдын эзэмшсэн байх мэдлэг, чадварыг өөрийн ажиглалт, сурагчдын үйл ажиллагааны явцад ажилласан дасгал даалгаврын гүйцэтгэлд үндэслэн шалгуур боловсруулан үнэлж болно. Жишээ нь: анги удирдсан багш сурагч бүрээр тэмдэглэл хөтлөн, хүүхэд бүрийн ахиц, өөрчлөлтийг дүгнэхээс гадна ангийн нийт сурагчдын ерөнхий хандлагыг тодорхойлох боломжтой.

Үнэлгээ: 1-сайжруулах шаардлагатай; 2- дунд зэрэг; 3-сайн гэж

Д/д	Суралцагчийн нэр	Үнэлэх шалгуур						
		Ажил мэргэжил, суралцах чиглэлтэй холбоотой мэдээлэл цуглуулах, цуглуулсан мэдээллээ боловсруулах хангалттай мэдлэг ойлголттой болсон	Өөрийн сонирхол, ур чадвар, арга барил, үнэт зүйлээ тодорхойлж, ирээдүйн ажил	Суралцах чиглэл, ажил мэргэжлийн урт хугацааны төлөвлөгөө гаргаж сурсан.	Ирээдүйн ажил мэргэжилтэйгээ уялдуулан ахлах ангийн хичээлээ сонгосон	Ажил мэргэжил, суралцах чиглэлийн талаар шийдвэр гаргахад нөлөөлөх хүчин зүйлийг зохицуулах чадварт ахиц гарч байгаа	Өөрийн сурлагын амжилтыг эргэн харж, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргаж сурсан.	.....
1	Б. Ариунаа	3						
2	Г. Батаа	3						
40	.....	2						
<b>Нийт</b>								
	1 оноо авсан суралцагчдын тоо	0						
	2 оноо авсан суралцагчдын тоо	9						
	3 оноо авсан суралцагчдын тоо	31						

**Ашиглах хэрэглэгдэхүүн, ном зүй / цахим онлайн, ном гарын авлага /**

АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд боловсруулан гаргасан

- ✓ Багшийн гарын авлага /ЕБСийн 8,9 дүгээр ангийн багш нарт зориулсан гарын авлага/ 2016 он
- ✓ Сонголтын 7 хоног. Суралцагчийн гарын авлага, 2016 он
- ✓ Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага, 2016 он
- ✓ Эцэг эхэд зориулсан гарын авлага, 2016 он
- ✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн сурагчийн дасгал ажлын ном/ 2018

<sup>2</sup> БСШУЯ, АХБ-ны “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” –“Багшийн гарын авлага”, УБ, 2016, хуудас 83

- ✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа /Ахлах ангийн багшийн гарын авлага/ 2018
- ✓ Ажил мэргэжлээ сонгох нь /ЕБС-ийн ахлах ангийн сурагчдад сонирхол, чадвар болон үнэт зүйлээ тодорхойлох, тохирох ажил мэргэжлээ сонгоход дэмжлэг үзүүлэх сорил/
- ✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа /Эцэг эх асран хамгаалагчид зориулсан зөвлөмж/
- ✓ Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг төлөвлөх нь /Сургуулийн удирдлагад зориулсан гарын авлага/ 2018

**Цахим эх сурвалж:**

- ✓ [www.myfuture.mn](http://www.myfuture.mn)
- ✓ [www.mergejil.mn](http://www.mergejil.mn)
- ✓ [http //hudulmur-halamj.gov.mn/occ](http://hudulmur-halamj.gov.mn/occ)
- ✓ [http //jobclass.ubstat.mn/occ](http://jobclass.ubstat.mn/occ)
- ✓ [www.onisep.fr](http://www.onisep.fr)
- ✓ [www.myworldofwork.co.uk](http://www.myworldofwork.co.uk)
- ✓ [www.careers.govt.nz](http://www.careers.govt.nz)
- ✓ <https://myfuture.edu.au>
- ✓ <https://www.onetonline.org>
- ✓ Их дээд сургууль, МСҮТ, коллежуудын вэбсайтууд

“Хөгжлөөс хэн ч хоцрох ёсгүй” тогтвортой хөгжлийн уриан дор ЕБС-ийн 8-12 дугаар ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг 2016 оноос эхлэн явуулж байгаа бөгөөд тогтвортой хөгжлийн боловсролын 4-р зорилт болох “Чанартай боловсрол”-ыг дэмжих үүднээс энэхүү үйл ажиллагааг улам чанаржуулах, тасралтгүй явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор ЕБС-ийн удирдлага, багш, сурагч, эцэг эхчүүдэд зориулсан онлайн орчин бүрдүүлж, цахим сургалтын модуль боловсруулсан.

Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт үйл ажиллагаа нь сурагч өөрийгөө таньж мэдэх, үнэт зүйлээ хамгаалах, ажил мэргэжлээ зөв сонгох, хөдөлмөрийг үнэлж сурахад нь дэмжлэг үзүүлэх, ерөнхий боловсролын тогтолцоонд үр дүнтэйгээр нэвтрүүлэх, багш, сурагч, эцэг эх, сургуулийн удирдлагын мэдлэг, чадвар, хандлагыг өөрчлөхөд дэмжлэг үзүүлэхэд чиглэнэ.

Иймээс нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд жендерийн эрх тэгш оролцоог дэмжиж, хөгжлийн үр шимээс эмэгтэй, эрэгтэй хүн тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, жендерийн мэдрэмжтэйгээр ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Түүнчлэн мэргэжил сонголтод жендерийн талаарх хэвшмэл хандлагаас сэргийлэн хичээл, үйл ажиллагааг мэдрэмжтэй удирдан зохион байгуулж охид, хөвгүүдийн боломж ижил тэнцүү байдаг талаас нь ойлгуулна.

Түгээмэл биш ажил мэргэжлийн талаар ярилцахдаа илүү мэдрэмжтэй байж охид, хөвгүүдийн тэгш оролцоог хангаж ажиллах, суралцагчдад аль болох олон төрлийн ажил мэргэжлийн талаар ойлгож мэдэхэд нь дэмжлэг үзүүлж ажиллана.



---